

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

I-р улирал

2025 он

Гүйцэтгэх захирлын мэндчилгээ



Практикал Даатгал ХХК-тай хамтран ажилладаг эрхэм харилцагч та бүхэнд энэ өдрийн мэндийг дэвшүүлье.

Манай компани анх үүсгэн байгуулагдсан цагаасаа эхлэн бүтээгдэхүүн, үйлчилгээгээрээ салбартаа манлайлагч нь байж, анхны онлайн даатгалын үйлчилгээ болон чанарын менежментийн ISO стандартыг нэвтрүүлэн, хот болон орон нутгийн бүх салбарууддаа хэрэгжүүлэн ажиллаж байна. Даатгал нь нийгмийн эрсдэлийг тодорхой хэмжээнд хуваалцаж цаашид өөрөө хөгжих боломжоор нь хангаж өгдөг хамгийн буянтай бизнес юм. Бид зах зээлд эзлэх хувиа нэмэгдүүлэн нийт харилцагч даатгуулагч, хөрөнгө оруулагч байгууллагууддаа илүү хариуцлагатай, шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг технологийн дэвшилтэй хослуулан хүргэж байна.

2003 оноос идэвхитэй үйл ажиллагаагаа явуулж буй манай компани харилцагч та бүхний дэмжлэгтэйгээр чадварлаг боловсон хүчин өсгөж хөгжүүлэн өдрөөс өдөрт өргөжин тэлж, цар хүрээ, ололт амжилтаа бататган өнөөгийн хамгийн шилдэг даатгалын компаниудын тоонд зүй ёсоор орж байгааг дуулгахад таатай байна.

Өдрөөс өдөрт улам хурдацтайгаар шинэчлэгдэн өөрчлөгдөж буй амьдралын хэв маяг, бизнесийн орчны ахиц дэвшил, түүнд учирч болзошгүй эрсдэлийг удирдахад туслахыг бид ямагт хичээн ажилладаг бөгөөд харилцагч, даатгуулагчидтайгаа хамтдаа сурч, хамтдаа хөгжиж, эрсдэлгүй нийгмийн сайн сайхны төлөө нэгэн зорилготой, нягт холбоотой хамтран ажиллана гэдгээ илэрхийлье. Эрхэм харилцагч, даатгуулагч та бүхний ажил үйлс өргөжин дэвжиж, аливаа эрсдэлээс ангид, ирээдүйд илүү итгэлтэй, амжилт бүтээл, аз жаргалаар дүүрэн байхын ерөөлийг өргөн дэвшүүлье!

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Н.ТҮМЭНДЭМБЭРЭЛ

Компанийн бүтэц

5 Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн

150 Үндсэн ажилтан

8 Газар хэлтэс

Газар хэлтсүүд

- Бизнес хөгжил, даатгалын бодлогын газар
- Байгууллагын борлуулалтын газар
- Иргэдийн борлуулалтын газар
- Нөхөн төлбөр, үйлчилгээний газар
- Санхүү удирдлагын газар
- Маркетингийн хэлтэс
- Эрсдэлийн удирдлагын хэлтэс
- Захиргаа, хүний нөөцийн хэлтэс

Бидний тухай

Очир-Ундраа Группийн охин компани болох Практикал Даатгал ХХК нь 2003 онд 100% үндэсний хөрөнгө оруулалттайгаар үүсгэн байгуулагдсан. Өдгөө 21 аймаг 24 салбар нэгж, 200 гаруй төлөөлөгч бүхий Монгол Улсын хамгийн хүртээмжтэй даатгагч юм.


Бид өнөөг хүртэл даатгалын салбарт шинэ өнгө төрх, шинэлэг бүхний анхдагч нь байж бүхний даатгуулагчдынхаа хэрэгцээ шаардлагад нийцсэн чанартай бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэхийг зорин ажиллаж байна.

Түүхэн замнал




Санхүүгийн үзүүлэлт

Нийт хураамж /тэрбум төгрөгөөр/




2025 оны 1-р улиралын байдлаар нийт хураамжийн орлого **7.2 тэрбум төгрөг** буюу өмнөх оны мөн үеээс 51.7%-аар буурсан байна.

Цэвэр хураамж /тэрбум төгрөгөөр/




2025 оны 1-р улиралын байдлаар нийт цэвэр хураамжийн орлого **5.7 тэрбум төгрөг** буюу өмнөх оны мөн үеээс 18.6%-аар өссөн байна.

Нийт хөрөнгө /тэрбум төгрөгөөр/




2025 оны 1-р улиралын байдлаар нийт хөрөнгө **41.7 тэрбум төгрөг** буюу өмнөх оны мөн үетэй харьцуулахад 13.1%-аар буурсан байна.

Нийт нөхөн төлбөр /тэрбум төгрөгөөр/




2025 оны 1-р улиралын байдлаар нийт олгосон нөхөн төлбөр **13 тэрбум төгрөг** олгосон буюу өмнөх оны мөн үетэй харьцуулахад 364%-аар өссөн байна.

Харьцаа үзүүлэлтүүд




■ Хохирлын харьцаа



■ Зардлын харьцаа

Нөхөн төлбөр

Практикал Даатгал ХХК гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж 2025 оны 1-р улирлын байдлаар 2,260 нөхөн төлбөрийн тохиолдолд 13 тэрбум төгрөгийг олгожээ.



Нийт тохиолдлын 78%-ийг агаарын хөлгийн даатгал, 7%-ийг автотээврийн хэрэгслийн даатгал 7%-ийг жолоочийн хариуцлагын даатгал эзэлжээ.

Нөхөн төлбөрийн хувийн жин /Бүтээгдэхүүнээр/

- Агаарын хөлгийн даатгал
- Авто тээврийн хэрэгслийн даатгал
- Жолоочийн хариуцлагын даатгал
- Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал
- Хөрөнгийн даатгал
- Бусад даатгал

Нөхөн төлбөрийн үйлчилгээ

Бид нөхөн төлбөрийн процесс болон харилцагчийн үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулах бодлогыг хэрэгжүүлж, харилцагч төвтэй хандлагыг үйл ажиллагааныхаа үндэс болгон ажилласан.

Үүний хүрээнд харилцагчдаас ирсэн гомдол, санал хүсэлтийг системтэйгээр хүлээн авч, бүртгэх, судлах, шийдвэрлэх дотоод журам, механизмыг боловсронгуй болгож, шийдвэрлэх хугацааг богиносгоход онцгой анхаарал хандуулсан.

Нөхөн төлбөрийн үйлчилгээний давуу талууд:



Харилцагчдад мэдээлэл, зөвлөгөө хүргэх тусдаа call center-тэй



Эрүүл мэндийн даатгалын зөвлөгөө өгөх, нөхөн төлбөрийг шуурхай шийдвэрлэх эмч нарын баг



Чатбот, имэйл, веб хуудас зэрэг боломжит сувгаар дамжуулан харилцагчдын санал хүсэлтийг хүлээн авдаг.



Нөхөн төлбөрийн дуудлагыг 24/7 хүлээн авч зөвлөгөө, чиглүүлэг өгөх, үзлэг баримтжуулалт хийх, нөхөн төлбөрийг шуурхай шийдвэрлэх мэргэжлийн баг ажилладаг.

Иргэдийн даатгал

Бид даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээг 21 аймгийн салбар, төлөөлөгч нараараа дамжуулан хүргэхээс гадна дараах сувгуудаар дамжуулан илүү хүртээмжтэйгээр ажилладаг.



Иргэдийн даатгалын бүтээгдэхүүн:

- Гэнэтийн ослын даатгал
- Жолоочийн хариуцлагын даатгал
- Авто тээврийн хэрэгслийн даатгал
- Малын индексжүүлсэн даатгал
- Хөрөнгийн даатгал
- Гадаадад зорчигчдын даатгал

Байгууллагын даатгал

Бид харилцагч байгууллагын үйл ажиллагааны онцлог, зонхилох эрсдэл зэргээс хамааран тохирох бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгон ажиллаж байна.



Авто тээврийн хэрэгслийн даатгал



Агаарын хөлгийн даатгал



Хариуцлагын даатгал



Гэнэтийн ослын даатгал



Барилга угсралтын даатгал



Зээлийн даатгал



Ачааны даатгал



Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал

Давхар даатгал

Практикал Даатгал ХХК нь Standard & Poors болон A.M.Best агентлагаас "A+" буюу түүнээс дээш зэрэглэл тогтоолгосон дэлхийн томоохон давхар даатгагч нартай хамтран ажилладаг.

Тухайлбал дэлхийн шилдэг давхар даатгагчдын нэг Hannover Re компанитай 2011 оноос эхлэн даатгалын бүтээгдэхүүнээ багцлан, багц даатгалын гэрээгээр давхар даатгуулсан. Иймд даатгуулагч та манай байгууллагад даатгуулснаар энэхүү гэрээнд шууд хамрагдаж давхар даатгалаар хамгаалагдаж байна.

Мөн банкны бүрэн хамгаалалтын даатгал, агаарын хөлгийн даатгал, ачааны даатгал, гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал, барилга угсралтын даатгал зэрэг төрлүүдээр давхар даатгалын хэлцлийг хийж, хэлцлийн онцлогоос хамааран 5% - 100%-ийн эрсдэлийг давхар даатгалд байршуулаад байна.



Биднийг сонгох шалтгаан

- Санхүүгийн чадамж
- Бизнесийн ёс зүй
- Түргэн шуурхай үйлчилгээ
- Нөхөн төлбөр олголтоор Монгол Улсын №1 даатгалын компани
- Даатгалын өргөн сүлжээ
- Найдвартай давхар даатгалын түншүүд
- Даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээний өргөн сонголт, мэргэшсэн компани
- Эрсдэлийн менежмент сайн компани

Томоохон харилцагчид

